

Г.Бямбасайхан-Хууль сахиулахын удирдлагын академийн
8032 дугаар дамжааны суралцагч.
э)агдаагиг/н хошууч

Б.Одбаатар -ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага. стратегийн профессорын багийн
профессор, хууль зүйн ухааны доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа

УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ УДИРДЛАГЫН АРГА БАРИЛ АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

*Хураангуй:*Дэлхийн улс орнууд удирдлагын “хүн төвтэй” стратегийг баримтлан улмаар нийгэм, байгууллагын хөгжил дэвшлийн эх сурвалж хүн гэж үзэх хандлага нийтлэг болж байна.

Дээрх хүн төвтэй ” стратегийг задлан огтчоговол олон талт ажлын арга барил эзэмшсэн удирдах албан тушаалтан нь алба хаагчдыг зөв удирдаж, хөгжүүлж чадвал тэд үр ашигтай хөдөлмөрлөж ажлын үр дүн гүйцэтгэлд нөлөөлж алба хаагч хөгжихийн хэрээр шинийг сэтгэж. эрэлхийлэх бүтээлч сэтгэлгээтэй болдог гэж ойлгохоор байна.

Өөрөөр хэлбэл нөхцөл байдлыг загварчлан системчлэх ойлгох чадвартай.нөхцөл байдлыг бүх талаас нь авч үзэн дүн шинжилгээ хийх буюу бодит байдлыг хийсвэрлэн сэтгэх.хийсвэр сэтгэлгээнээс бодит байдалд шилжиж аливааг урьдчилан харж хариу үйлдэл хийх чадвартай, гадаад болон дотоод орчны хучин зүйлсийг үнэлэн алба хаагчдынхаа цаашдын төлөв байдлыг ойлгох өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх оюолын болои практик мэдлэгийг хослуулах нь ажлын арга барил юм.

Түлхүүр үг: Удирдлагын арга барил, Удирдагч , удирдагчийн хэв шинж, авъяас

Үндсэн хэсэг

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтий хэв журам хамгаалах.олон нийтийн аюулгүй байдлыг үр дүнтэй ханган биелүүлэх, амжилттай ажиллах чухал нөхцлийн нэг нь яахын аргагүй удирдах албан тушаалтны удирдлагын арга барил, алба хаагчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөх бодлогын асуудал байдаг.

Өнөөгийн нийгмийн хөгжил өөрчлөлтийн дагуу шинэчлэгдэж буй энэ үед цагдаагийн байгууллагын эрхэм зорилго. стратегийг өндөр үр дүнтэй, бүтээмжтэй хэрэгжүүлэхэд удирдах ажилтаны төрөлх оюун ухаан, алсын хараа, бусдын итгэл хүлээсэн байдал, тал бүрийн өргөн мэдлэг, удирдан зохион байгуулах ажлын арга барил, ур чадвар, бүтээлч байдал зэргийг яахын аргагүй шаардаж байдаг.

Иймээс цагдаагийн байгууллагын удирдлагын бодлогыг удирдлагын шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Мэдээж удирдах ажилтны удирдлагын арга барил алба хаагчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөх энэ чухал асуудал урсгалаараа явбал биеллээ олж чадахгүй. Иймд уг асуудлыг шинжлэх ухааны судалгааны үндэслэлтэй бодлогын түвшинд авч үзэж чадварлаг алба хаагчдын залгамж халааг бэхжүүлж, цагдаагийн байгууллагад ажиллах боловсон хүчин. тэднийг мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, элсүүлэх, сонгох, дадлагажуулах, тэдэнд үзүүлэх дэмжлэг тусалцааг үндэстэй тодорхойлж алба хаагч нарт үзүүлэх ажлын арга барил нь тулгамдсан асуудлын нэг болсон байна.

Мөн төрийн өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ард түмнийхээ амар амгалан, тайван амьдрах нөхцөл бололцоог бүрэн дүүрэн хангахад яах аргагүй удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох удирдах албан тушаалтны ажлын арга барил алба хаагчийн ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж буйг судалж шинэ түвшинд гаргах шаардлага үүссэн гэж үзэж байна. Судалгаагаар байгууллагын өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх алба хаагчидтай холбогдсон нөөцийг илрүүлэн ашиглах ажлын 70 хувь нь удирдах ажилтны удирдлагын арга барил авьяас чадвараас хамаардаг гэсэн дүгнэлт судалгааны дүн байдаг.

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтан нь удирдан зохион байгуулж, төлөвлөж, удирдах албан тушаалтны удирдлагын арга барил, алба хаагчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөж хөгжүүлж чадвал тухайн байгууллага, алба нэгж, алба хаагч нар үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ түүний бүтээлч чадамж нь бодитоор илэрч улмаар байгууллага олон талт үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, өмнөө тавьсан стратеги зорилгодоо амжилттай хүрч чаддаг.

Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтаар хангах, өнөөгийн явуулж буй удирдах ажилтны удирдлагын арга барил алба хаагчийн ажлын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг дээшлүүлэх бодлогын хэрэгжилтэнд гарч буй алдаа, зөрчил дутагдал, түүний шалтгаан үр дагаварт үнэлэлт дүгнэлт өгч, түүнээс гарах арга замыг боловсронгуй болгоход чиглэсэн заавар зөвлөмж, судлагдсан байдал байхгүй байгаа нь уг сэдвийг зайлшгүй судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байна.

Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны удирдлагын арга барил, алба хаагчийн ажлын гүйцэтгэлд нөлөөлөх асуудалд тулгамдаж байгаа зарим асуудлыг тодорхойлон, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхэд анхаарах боловсронгуй болгох, ингэхдээ цагдаагийн байгууллагын түүхэн уламжлал болон хөгжингүй орнуудын туршлагыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан судлах нь зүйтэй юм.

Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан та бүхний мэдлэгт бага ч болов мэдээлэл өгөх, удирдах урлаг, удирдагчийн талаарх үзэл, бодлыг тань тэлэхэд онолын ач холбогдол оршино.

Мөн практик ач холбогдол нь удирдах урлаг, удирдагчийн талаарх мэдлэгтэй болсноор еерее есртее дүгнэлттэй хандаж, хувийн зохион байгуулалт сайжирч, мөн алхам дутамдаа удирдах арга барилд суралцахад ечуухэн ч атугай дагаж мердех үзэл телевизүүлэхэд практикийн ач холбогдол оршино.

“Удирдагч”энэ угийг сонссон хэний ч сэтгэлд нэг л сүрдмээр бас бахархмаар сэтгэгдэл терж буй за.

Аль ч нийгэм улс ундэстэн, ер нь нийт ХҮН терелхтнийг удирдан-жолоодож явдаг жинхэнэ удирдагч байдаг.

Гэхдээ “ Эрх барих амархан удирдах хэцүү” хэмээн Германы их соён гэгээрүүлэгч Гёте хэлсэнчлэн ХҮН бvр удирдагч болдоггүй. Туухийн хурдийг эргүүлэхэд сод билэг удирдагч ХУМУУНЭЭ тухайн цаг ve нь еерее теруулдэг жамтай. Цаг хугацаа хэмээх унэний шалгуураар дэнслэгдэж ХҮН терелхтний ТУУХЭНД нэрээ менхелж чадсан удирдагчид цеенгуй байдаг билээ.

Гэхдээ тэдний дундаас удирдах арга барилыг тегс эзэмшсэн жинхэнэ удирдагч нь хэд билээ. Манай дэлхий дээр амьдрал бий болж, ХҮН терелхтен VVCCDN цагаас ХҮН ХУНЭЭ удирдан жолоодох урлаг хийгээд туунийг бүтээлчээр хэрэгжуулэх удирдагчид нь бэлтгэгдсээр иржээ.

Удирдагч гэж ярихын емне удирдагч гэж хэн болох, хэзээ уУССЭН талаар тодруул юу. Удирдагч гэдэг нэр томъёог МЭС 232 онд Грекийн эрдэмтэн Мосе анх дэвшүүлж байсан бегеед энэ талаар МЭӨ 230 онд хуралдсан Грек эрдэмтдийн цуглаан дээр хоёр эрдэмтэн ЭНЭХУУ саналыг дэмжиж удирдагчын дараах шинж чанаруудыг гаргажээ.

үүнд:

1. Бодох
2. Телевлех
3. Удирдах

Удирдагч гэдэг нь терийн ч, эдийн засгийн ч, нийгмийн ч ер нь аль ч салбарт удирдах урлагийг хийх ХУНИЙГ хэлнэ. Еренхийдее удирдах урлаг нь иргэдийн 1 хэсгээс боломжийнх нь хэрээр аль боломжтойг нь авч негее хэсэгт өгөхөд оршино хэмээн их tvH ухаанч Вольтер хэлсэн байдаг.

Удирдагч нь бусад ХVMVVCT ургэлж хэрэпэй байдаг ХҮН гэж хэлсэнчлэн удирдагчгуйгээр дээшилж тодорсон ард түмний тухай ТУУХЭНД vrvft бегеед харин эсрэгээрээ сайн удирдагчаас б\хий л зүйл шалтгаалж байсан байдаг. Шатны хамгийн дээд гишгуур дээр олон ХҮН шуугилдаад л байдаг, харин хэн ч

бууж ирдэггүй” гэж эртний хятадын ҮГЭНД хэлсэнчлэн XVH бvр удирдагч байж болохгүй. Удирдагч нь тухайн цаг ve, тухайн орчинд ганц л байх ёстой.

Снгерсен уеийн удирдагчдын удирдлагын арга барил дур к рхийг хуний нпийгмийн хөгжлийн явцтай нь холбон авч увзэл зохилтой.

1 .X\ й нэгдлийн ve буюу манай эриний емнех \ед XVМVVC овгийн зохион байгуулалттай байсан. Араатан амьтдын сургийн дотор аль хучтэй нь сургийн толгойлогч болдог шиг тэр уед овог дотроо хамгийн хучтэй, биеийн хөгжил сайтай нь удирдагч болж байсан.

2. Дундад зууны уед аль их херенге менге эд баялагтай нь эрх мэдэл удирдлагыг хүчээр гартаа авч удирдагч болж байсан. Тоффлерийн "Эрх мэдлийн шилжилт" номонд:" Эрх мэдэл, удирдлагыг олж ирдэг ундсэн 3 хэрэгслийг менге зэвсэг мэдээллэл" гэсэн байсан нь дээрхийн нотолгоо мэт. Гэхдээ энэ уед хараахан мэдээллийн унэ цэнэ тодроогүй байсан.

3. Орчин уед оюун ухаан, мэдлэг боловсрол, унаган давуу талтай, удирдах авьяастай удирдлагын олон талт арга барилтай XVМWC удирдагч болон тодорч нийгмийн хөгжлийг жолоодож явна.

Ийнхүү енгерсен туухээ шинжлэн харж, ирээдүйгээ тесеелен бодохын зуур жинхэнэ удирдлагын арга барил эзэмшсэн удирдагч гэж чухам хэн юм бэ? Жинхэнэ удирдагч байсан уу? гэх бодол еерийн эрхгүй терне.

Эртний Хятадын гүн ухаанч, философич Ли Эр / Лаоз/: “Хэрэв XVМVVC чиний араас дагаасай гэж ХУСЧ байвал еерее тэдний араас яв” гэж хэлсэнчлэн жинхэнэ удирдагч XVH ГЭДЭГ нь ард олныхоо амьдралаар нь амьдарч, зовлонгоор нь зовж, жаргалаар нь жаргаж тэдэнтэйгээ нэгэн бул болж чаддаг хумуунийг хэлнэ.

Өөрөөр хэлбэл нөхцөл байдлыг загварчлан системчлэх ойлгох чадвартай, нөхцөл байдлыг бүх талаас нь авч үзэн дүн шинжилгээ хийх буюу бодит байдлыг хийсвэрлэн сэтгэх, хийсвэр сэтгэлгээнээс бодит байдалд шилжиж аливааг урьдчилан харж хариу үйлдэл хийх чадвартай, гадаад болон дотоод орчны хүчин зүйлсийг үнэлэн алба хаагчдынхаа цаашдын төлөв байдлыг ойлгох өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх онолын болон практик мэдлэгийг хослуулахыг хэлж болох юм.

1. Удирдахуйн арга барил ур чадвар/гадаад /

2. Удирдагчийн мен чанар /дотоод сэтгэл / гэсэн асуудлуудыг дэлгэрүүлэн авч уулээ.

Удирдагчийн ур чадвар /гадаад/ Монголын эртний хаан Атилла нь дараах зарчмуудыг удирдах урлагтаа ашиглаж байжээ.

үүнд:¹

¹ Цэцэгмаа. Хүний нөөцийн менежмент. УБ.. 2001он

- 1) ХҮНИЙ чин ҮНЭНЧ чанарыг эрхэмлэх
 - 2) Эр зоригийг эрхэмлэх
 - 3) Эрхэмлэх ХҮСЭЛ эрмэлзэлтэй ХҮН амжилтанд хүрдэг
 - 4) Сэтгэлийн тэнхээтэй
 - 5) Биеийн тэнхээтэй
 - 6) Хүнд ЖИНХЭНЭ ёсоор ХҮНДЛЭГ-ДЭЖ чаддаг
 - 7) Эрс шийдэмгий
 - 8) Аливааг урьдчилан хардаг
 - 9) Цагийг ҮНЭЛЖ чаддаг
 - 10) Өрсөлдөгчөө ҮНЭЛЖ чаддаг -
 - 11) Өөрөө өөртөө итгэлтэй
 - 12) Аливаад эхнээс нь тооцоотой хандаж чаддаг
 - 13) Хариуцлагаа ГҮНЭЭ ухамсарладаг
 - 14) Зорьсон зорилгоосоо няцдаггүй
 - 15) Итгэл найдвар даадаг
 - 16) Нөмөр нөөлөгтэй, ТҮШИГТЭЙ
 - 17) Бусдыг байлдан дагуулах зэрэг ТҮҮНИЙ ЭНЭХҮҮ удирдахуйн ур чадваруудыг
- Чингис хаан бишрэн ШҮТЭЖ, өөрийн үйл ажиллагаандаа бүтээлчээр хослуулан хэрэглэж байсан юм. Эндээс харахад одоогийн орчин нөхцөлд жинхэнэ удирдагч ХҮН дээрх удирдлагын арга барил чадвар эзэмшсэн байхад илүүдэхгүй буй за.

Удирдагчийн мөн чанар /дотоод сэтгэл/

ХҮН гэдэг өөрөө Зүрх сэтгэлийн амьтан юм. Иймээс ч ХҮНИЙ амьдралын их багш болбоос ХҮНИЙ дотоод сэтгэл юм. Удирдагч ХҮН ГЭДЭГ зүрх сэтгэл, дотоод ХҮНЭЭ үргэлж чагнаж байх ёстой. Удирдагч ХҮНИЙ дотоод сэтгэлд дараах эрхэм шинж арга барил ямагт байх ёстой юм.

1 .Удирдагч ХҮНИЙ хамгийн эрхэм чанар болбоос “ӨӨРИЙГӨӨ БУСДЫН төлөө ЗОРИУЛАХ”. Өөрөөр хэлбэл удирдагч ХҮНИЙ амьдрал өрөөлийн төлөө өөрийгөө залж зориулахад оршино.

Энэ утгаараа удирдагч байна гэдэг “Өөрийгөө ялж гарах аугаа их сорилт юм”. Учир нь БИ гэж бодохоосоо ИЛҮҮ ТЭД гэж бодож, тэдний төлөө шаналж, тэдний төлөө амьдрах ухамсарт замаар замнадаг.

2 . Жинхэнэ удирдагч ХҮН ГЭДЭГ өөртөө хэн бүхэн ХҮЛЭЭН зөвшөөрсөн бодит нэр ХҮНДИЙГ бий болгох ёстой. ХҮНИЙ олон талт үйл ажиллагаанаас илэрсэн сайн талуудын ҮНДСЭН дээр бий болсон итгэл ХҮНДЛЭЛИЙГ нэр ХҮНД гэнэ. Нэр ХҮНД бүрэлдэн тогтох ҮНДСЭН зам нь удирдагч ХҮН ард ТҮМНИЙХЭЭ төлөө амь биеэ хайхралгүй ЗҮТГЭХ явдал юм.

Алдар нэрийг олж авах хэцүү, олж аваад хадгалах бүр хэцүү гэсэнчлэн удирдагч ХҮН өөрийн нэр төрөө ямагт ХҮНДЭТГЭН хайрлах ёстой.

ХҮН удирдана гэдэг ҮНДСЭНДЭЭ ХҮНИЙ зүрх сэтгэлийг таньж мэдэх, түүнийг эзэмдэх урлаг юм. Сөрөөр хэлбэл удирдагч ХҮНИЙ, бусдын зүрх сэтгэлийг харж таньж чаддаг билгийн НҮД арга барил хурц байх ёстой. Биенийг нь хураах гэвэл Сэтгэлийг нь тат Сэтгэлийг нь татвал бие нь хаа холдох вэ? хэмээн Эзэн богд Чингис хэлжээ. ХҮНИЙ сэтгэлийг хураах хамгийн сайн эрдэм бол удирдаж буй хүнийхээ сэтгэлийг ойлгох. Ингэхийн тулд хэлж буй бухнийг нь сонсч, ХҮСЧ буй бухнийг нь мэдэрч түүнтэй НИЙЦҮҮЛЖ шийдвэр гаргах юм.¹

Удирдагч ХҮНИЙ сэтгэл, сэтгэлгээ гэдэг ургэлж залуу, шинэлэг байх ёстой. Ийм ч учраас "Улиг домог болсон хэв шинжит зүйлсийг угээрээ ч, үйл ажлаараа ч тойрч бай" хэмээн эртний их сэтгэгч Пифагор хэлсэн бизээ.

Удирдагч ХҮНИЙ онцлог шинж нь хэр зэрэг зарчимлаг амьдарснаар тодорхойлогдоно. Иймээс жинхэнэ удирдагч ХҮН өөрийн удирдахуйн философи, амьдралын зарчимтай байх ёстой.

Жишээ: Чингис хааны удирдахуйн гол философи нь " Хүчтэй байх явдал бөгөөд би чамайг няц дарна. Тэгээгүй цагт чи намайг няц дарна. Би юу? Чи юу?" гэсэн зарчимд тулгуурлаж байжээ.

Жинхэнэ удирдагч нь сэтгэл зүйн хувьд хамгийн ХҮЛЦЭНГҮЙ, ууч, егөөмөр байх нь түүний амжилтын бас нэгэн тулхуур билээ. Жишээ: Хаан ХҮНИЙ 35 эрдмээс хамгийн чухал нь хайрлах эрдэм юм. Чингисийн хамгийн хатуу шийтгэл нь уучилж шийтгэх явдал байсан юм.

Эх дэлхий маань даяарчлагдаж байна. Даяарчлалын серег үр дагавраас хамгаалах, ҮНДЭСНИЙ дархлаа бий болгох гол ХУЧИН ЗҮЙЛ нь эх оронч үзэл юм. Удирдагч ХҮНД ҮНДЭСНИЙ эх оронч үзэл зайлшгүй байх шаардлагатай.

Энэ бүх удирдах арга барилыг эзэмшиж, ХУМУУНИЙ СЭТГЭЛИЙН сайхныг биедээ шингээсэнээр жинхэнэ удирдагч нь ХҮН терөлхтний хамгийн сайн сайхан, шударга ЗҮЙЛИЙН бэлэг тэмдэг болох ёстой гэж би хувьдаа боддог юм.

Сайн удирдагч байхын тулд дараах удирдлагын арга барилыг эзэмшсэн байвал зохилтой

Удирдах ухаан удирдлагын арга барил хүн бүрд заяасан байдаг. Өөрийгөө удирдахаас эхлээд өрх гэр, хамт олон, хамаг улсаа удирдах хүртэл. Гэхдээ энэ ухаан нь хөгжсөн хөгжөөгүйгээрээ л ялгаатай юм. Удирдах ухаанаа авьяас, чадвар болтол нь хөгжүүлэхэд хүн өөрөө ч хичээж, хүмүүс ч түүнд туслахаар ирсний хүчинд хүн төрөлхтөн түүхнээ мөнхөрсөн өдий төдий удирдагчийг төрүүлж бас төржээ. Удирдах ухааны өөрөө сурах бичиг нь

4. <http://haiime.blog.tiogo.mn/read/entrv290412> 2. байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.,2017он

амьдрал. хүмүүс юм. Сайн удирдагч хүн маш олон чадварыг эзэмшсэн байх хэрэгтэй ба удирдагч нь дараах чадваруудыг эзэмших хэрэгтэй байдаг.

Удирдагч нь ёс зүйт чанартай хүн байх ёстой

Далд амьдрал гэж удирдагч хүнд байдаггүй. Учир нь олны нүдэнд ил харагдаж байгаа бүхэн нь түүний далд амьдралын тусгал болдог билээ. Мэдээж, жүжиглэх, хэлбэр гаргаж нэг хэсэг явж болохыг үгүйсгэхгүй ч цаг хугацаа эзсийг нь гаргадаг хорвоогийн хатуу хууль үйлчилдгийг мартаж болохгүй. Удирдагч хүний далд амьдрал буюу түүний амьдралын философи, итгэл бишрэл, хувийн зан чанар, мораль, гэр бүлийн амьдрал, тэр ч бүү хэл хувийн сахилга бат хүртэл түүний ил зогсох дүр төрхийг бүтээж байдаг билээ.¹

Удирдагч хүний амжилт хоёр үргэлж нийцдэг

Хүний үг бол түүний нэр хүнд юм. Хүн амлалтаа биелүүлэхэд түүнд итгэх хүмүүсийн итгэл өсдөг. Тэр хэмжээгээр түүний нэр хүнд дээшлэх болно. Харин амлалтаа эс биелүүлвэл, нэр хүнд нь унах болно. Удирдагч хэлсэн үгээ мартсан юм шиг дүр исгэж болох авч ард түмэн удирдагчийн үгийг хэзээд санаж байдаг.

Удирдагч хүн яагаад гэдгийг үргэлж мэддэг хүн байдаг

Ажлыг яаж хийхийг мэддэг хүн үргэлж ажилтай, харин яагаад, ямар учраас гэдгийг мэдэж байгаа хүн үргэлж удирдагч байдаг гэсэн алтан дүрэм бий. Мэдлэг, чадвартай, авьяастай хүн ажлыг "хэрхэн" хийхээ мэддэг бол харин удирдагч хүн "яагаад" энэ зүйлийг, ийм цагт, ийм байдлаар хийх ёстойг мэддэг. Хэрэв удирдагч хаашаа явж байгаагаа, яагаад явж байгаагаа мэдэхгүй бол сохор нь сохроо газарчлах гэгч болох болно.

Удирдагч хүн нөлөөгөө зөв шалтгаанаар, зөв байдлаар илэрхийлэх ёстой

Удирдах урлаг гэдэг бол хүнд нөлөөлөх урлаг юм. Хүнд нөлөөлж чадахгүй хүн яаж бусдыг удирдах билээ. Удирдагч хүн юу нь зөв, юу нь сайн, юу нь ариун, юу нь ёс зүйт, юу нь сайхан, юу нь сайшаалтай гэдгийг ялгах чадвартай байх ёстой. Тэгээд түүнд өгөгдсөн нөлөөг зөв байдлаар илэрхийлэх учиртай билээ.

Хүмүүстэй харилцах чадвар

Удирдлагын чадваруудаас хамгийн чухал нь удирдагчийн хүмүүстэй харилцах чадвар байдаг. Хүмүүстэй харилцаж чаддаг бол цаашид ахих боломж өндөр байдаг.

¹ Цэцэгмаа. Хүний нөөцийн менежмент. УБ.. 2001он.
<http://hajime.blog.gogo.mn/read/entry290412>

Бусдыг ойлгох

Удирдагч хүн олон зан аранштай хүмүүстэй харилцах болно. Иймээс хэрэв тэднийг ойлгож, сул болон хүчтэй талуудыг нь нээж чадвал харьцахад хялбар байх болно.

Илэн далангүй байх

Бусдыг мэхлэхийг оролдох хэрэггүй. Жирийн нэг ажилтан таны бодож байгаагаас хавьгүй ухаантай гэж бод. Хэдийгээр тар намхан духтай, бүрэг хүн шиг сэтгэгдэл төрүүлж болох ч тэр таны мэхлэх гэж байгааг тань дор нь мэдэх болно. Түүнд бүү их зан гарга. Тэр үүнийг ч бас ойлгоно. Хүмүүстэй харьцах цорын ганц арга бол шударга, илэн далангүй байх явдал.

Дотно найрсаг үгс

"Би чамайг үгүйлсэн шүү!" Зөвхөн гуравхан л үг. Гэхдээ хүний сэтгэлд яаж бууж байна. "Чиний ирсэн чинь ямар сайн юм бэ" гэсэн хэдхэн үг хүнд ямар хэрэгтэй болохыг мэдрэх хэрэгтэй. Иймэрхүү арга барил менежментэд маш чухал байдаг.

Ажил бүр чухал

Ариун цэврийн өрөө цэвэрлэдэг ч бай, циркэд үзүүлбэр тоглодог ч бай бүх л ажил чухал. Ямар ч ажил байсан хүн бүрт хийж байгаа ажил нь чухал гэдгийг ойлгуул. Хамгийн даруу хүн ч магтуулах дуртай шүү дээ.

Урам зориг ба санаачлага

Та ажилчдынхаа ажлын цагийг худалдан авч чадна. Та үүнийг тодорхой хугацаанд дэргэдээ байлгаж чадна. Гэхдээ та хүний урам зориг, санаачлага сэтгэл зүтгэлийг худалдан авч чадахгүй. Энэ бүгдийг та өөрөө олж авах ёстой.

Хүмүүсийг хүндэл

Хүч хэрэглэснээр хүн юунд ч хүрэхгүй. Хахууль өгөхийг завдах нь илжгийг луувангаар хуурах гэж оролдохтой адил. Харин хүн бүрт таарах нэг л арга байдаг. Энэ нь хүнийг ойлгох, хүндэтгэх хувь хүний зүтгэлийг зөв үнэлэх явдал. Зөвхөн энэ л арга хүмүүсийг зөв чиглэлд хандуулж чадна.

Хүмүүсийн нэрийг тогтоо

Хүмүүсийнхээ нэрийг тогтоо. Та үүндээ хэзээ ч харамсахгүй. Хүнийг нэрээр нь мэддэг байх нь таныг асуудал шийдэхэд хэдэн алхам урагш ахиулж өгнө.

Ажилчид тань ажлаараа бахархдаг байх нөхцлийг бүрдүүлж өг

Дарга нар ажилчдыгаа манай компани, манай үйлдвэр гэж ярихад дуртай байдаг. Ажиллаж байгаа компани чинь та нарынх юм шүү гэдгийг хүмүүст ойлгуул. Тэдэнд ажиллаж байгаа байгууллагаараа бахархах боломжийг олго. Амьдрал мэддэггүй, ихэмсэг, олж байгаа ашгийг нь хуваагаад авчихдаг хэдэн

дарга нарын төлөө ажиллаж байгаа мэт сэтгэгдэл ажилтнуудад төрөх нь элбэг байдаг. Ийм үзэлтэй хүмүүсийг та дайчилж ажиллуулж чадахгүй.

Ажилдаа анхаарч бай

Томоохон байгууллагын нэг асуудал бол ажилтнаа анхаардаггүй явдал байдаг. Тэднийг агуу том механизмын эрэг шураг төдий бодож хандаж болохгүй. Хүн гэдэг бол хүн л байдаг юм болохоор тэдэнд анхаарал хэрэгтэй. Тэд ямар нэгэн аргаар бусдын анхаарлыг татахыг хичээдэг. Ажилтнуудтайгаа яриа дэлгэж, аар саар зүйлээс эхлээд ажил хэргээ хүртэл ярилцаж бай. Тэдний санал бодлыг сонирхож сонсдог танд үүний тань үр дүн тун удахгүй харагдах болно.

Дэлхий ертөнцөд маш олон шилдэг агуу удирдагчид төрөн гарч байсан гарсаар ч байгаа. Энэ дундаас дэлхийн талыг эзлэн их гүрнийг байгуулж, орчин үед өөрийн удирдан дагуулах ухаанаараа гайхагдаж байгаа суут жанжин эзэн Чингис хааны удирдах ухааны талаар дараах мэдээлэл байна. Тэрээр удирдагч хүний бүхий чанаруудыг эзэмшсэн хүн байсан гэдгийг түүх баталдаг юм.

Удирдах ажилтны сэтгэл зүйн онцлог

Улс орны эдийн засаг нийгэм улс төрийн бүх хүрээг хамарсан өөрчлөн байгуулалтын эд өрнөлийн энэ үед нийт иргэдийн сэтгэл зүйн хандлагыг ардчилал зах зээлийн харилцаанд бүрэн зохицож чадахуйцаар өөрчлөх нь улс орны хөгжлийн гол түлхүүр юм.

Манай орон зах зээлийн харилцааны шинэ тогтолцоонд шилжиж буй энэ үед үйлдвэрлэлийг зөв зохистой явуулж, үр ашгаа дээшлүүлэхийн тулд удирдах ажилтныг оновчтой зөв шилэн сонгох хэрэгтэй.

Энэ нь аливаа байгууллага амжилтанд хүрэхийн тулд удирдах ажилтны сэтгэл зүйн онцлог, авьяас чадвар, хүсэл сонирхол боломжийг харгалзан үздэг системд шилжих нь нийгмийн шаардлагыг хангана гэж үзэж байна.¹

Удирдагч бол байгууллага хамт олны зорилго зорилтыг тодорхойлж зорилгодоо хүрэх бодлого боловсруулан хамт олон хүмүүсийг удирдан зохион байгуулагч нь юм.

1. Удирдагч хүн улс төрийн ойтой, эрдэм номтой, ухаалаг, сэхээтний шинжтэй, юмыг мартдаггүй, өнгөрсөн үйл явцыг сайн мэддэг байх.

2. Нийгэмч хамтач үзэлтэй, хүмүүсийн эрэлт хүсэлтийг эгзэгтэй тэвчээртэй үед хүмүүст тусалдаг, сонсож тусалдаг, жаргал зовлонг хуваалцдаг

Удирдах ажилтанд тавигддаг шаардлагууд маш олон сэтгэл зүйн хүчин зүйлсээс хамаарна.Тухайлбал

- Сэтгэн бодох чадвар
- Ноён нуруу

¹ <http://hajime.blog.gogo.mn/read/entry29041>

- Биеэ барих чадвар
- Ажил хэрэгч чадвар
- үнэнч шударга зан
- Аливаа юманд хэр хэмжээ байдгийг мэдрэн чадвар
- Санаагаа бичгээр болон амаар товч тодорхой илэрхийлэх чадвар
- Эрх тушаалаа ашиглах чадвар
- Мэдлэгээ шинэ з үйлсээр сэлбэх эрмэлзэл
- Тусгай мэргэжил
- Соёлын х үрээг тэлэх эрмэлзэл
- Орчин үеийн асуудлыг эзэмших
- Туршлага болон алдаан дээрээ суралцах зэрэг сэтгэл зүйн шаардлагуудыг удирдах ажилтанд тавьдаг байна.

Удирдах ажилтаныг дотор нь сэтгэл зүйн хувьд 9 хэв шинжид ангилдаг.

- Хатуу удирдагч
- Зөөлөн удирдагч
- Өөрийнхөөрөө зүтгэдэг боловч шударга удирдагч
- Шийдмэг боловч уян хатан удирдагч
- Чиглэсэн зорилготой өөртөө итгэмтгий удирдагч
- Шинийг сэтгэгч боловч юм бүхнийг гэдэг удирдагч
- Өөдрөг үзэлтэй бодит байдалд тулгуурладаг удирдагч
- Захирч тушаамтгай боловч дарж номхотгохыг уритал болгодоггүй удирдагч
- Ширүүн удирдагч

Дээрх бүх удирдагч нь зохион байгуулах авьяас чадвартай байх ёстой.

Ажиллах чадвар, идэвх санаачилгаас шалтгаална . Байгууллагын өмнө тавигдсан зорилтыг нэр төртэй , өндөр үр ашигтай биелүүлэх, бүтээлч хамт олныг амжилттай бүрдүүлэх нь ихээхэн ач холбогдолтой. Удирдан зохион байгуулах ажил хийхэд хүний зохион байгуулах төрөлхийн авьяас , сэтгэл зүйн онцлог чухал нөлөөлдөг.

Удирдахуйн үйл ажиллагааны цөм хэсэгт хүмүүс байх хийгээд тэд өөрийн гэсэн үзэл бодол, эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхол, амьдралын асуудалтай байдаг. Энэ бүхнийг харгалзан үзэж зохицуулан зохион байгуулж үйл ажиллагааг хэвийн явуулна гэдэг бол маш нарийн эв дүй ур ухаан, тэсвэр тэвчээр, авьяас чадвар шаардсан ажил болох нь тодорхой.

Тодорхой салбараар мэргэжил боловсрол эзэмшсэн ажлын туршлагатай бол дурын хун удирдах ажил хийж болно гэдэг хандлага бол өрөөсгөл алдаатай ойлголт юм.